



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2022/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн хот
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг: Dabaanyam.B@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал: Ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14-15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөнчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/159
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Г.ДАВААЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн хүнсний материал дансны жилийн эцсийн үлдэгдэл нь 27.8 сая төгрөг бөгөөд үүнээс 11.9 сая төгрөгийн 7 нэр төрлийн бараа материал нь түргэн муудах чанартай бүтээгдэхүүн байна. Эдгээр 7 нэр төрлийн 11.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг түүвэрчлэн цахим болон биет хэлбэрээр тооллого хийхэд байгууллагын агуулахад биетээр байхгүй хүнсний материал дутагдсан зөрчил илэрсэн нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.6.-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтад нийцэхгүй “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,651,186.17	110,243,764.57
33	АВЛАГА	00.00	250,455.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	250,455.00
35	БАРАА МАТЕРИАЛ	98,651,186.17	109,993,309.57
351	Түүхий эд материал	21,597,395.40	25,170,068.80
35110	Тусгай зориулалттай материал	19,188,695.40	23,507,848.80
35130	Эм боох материал	2,408,700.00	1,662,220.00
354	Хангамжийн материал	77,053,790.77	84,823,240.77
35410	Бичиг хэргийн материал	714,755.00	857,105.00
35420	Аж ахуйн материал	690,000.00	4,685,840.00
35440	Түлш, шатах тослох материал	169,050.00	48,300.00
35450	Барилгын засварын материал	00.00	3,284,700.00
35460	Хүнсний материал	29,143,230.00	27,788,550.00
35470	Бусад хангамжийн материал	46,336,755.77	48,158,745.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,552,713,266.30	1,578,470,340.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,552,713,266.30	1,578,470,340.93
392	Биет хөрөнгө	1,547,225,266.30	1,572,047,340.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,497,929,019.00	1,497,929,019.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,289,729.41	-83,977,409.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,059,025.50	101,242,426.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,517,641.08	-22,997,516.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,093,406.00	61,557,311.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,623,031.55	-12,919,615.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,291,881.20	33,533,699.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,491,881.36	-5,094,792.16
39217	Ном	2,774,218.00	2,774,218.00
393	Биет бус хөрөнгө	5,488,000.00	6,423,000.00
39301	Програм хангамж	737,000.00	935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-737,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,488,000.00	5,488,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,651,364,452.47	1,688,714,105.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	650,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	650,000.00
413	Өглөг	00.00	650,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	650,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,651,364,452.47	1,688,064,105.50
51	Засгийн газрын хувь оролцоо	1,651,364,452.47	1,688,064,105.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	136,211,492.70	136,211,492.70
51101	Өмч: - төрийн	136,211,492.70	136,211,492.70
512	Хуримтлагдсан үр дүн	1,297,987,742.68	1,335,000,036.55
51210	Өмнөх үеийн үр дүн	1,297,987,742.68	1,298,300,383.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	36,699,653.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,165,217.09	216,852,576.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,651,364,452.47	1,688,714,105.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,710,143,524.00	483,632,563.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,236,491,824.00	54,066,063.25
120	Нийтлэг татварын бус орлого	1,236,491,824.00	54,066,063.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,236,491,824.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,236,491,824.00	00.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/		49,430,663.25
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/		4,635,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,327,600.00	60,872,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	411,324,100.00	368,693,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,061,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,061,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,327,600.00	59,811,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,327,600.00	59,811,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	472,509,358.13	446,912,910.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,509,358.13	446,912,910.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,451,577.13	438,624,897.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,494,171.00	257,707,440.00
210101	Үндсэн цалин	257,494,171.00	257,707,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,178,656.00	35,271,836.00
210201	Тэтгэврийн даатгал	22,926,506.00	27,016,103.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,574,942.00	2,068,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,059,952.00	1,654,801.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,661.00	410,807.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,106,595.00	4,121,624.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,718,637.00	55,732,806.00
210301	Гэрэл, цахилгаан	2,734,397.00	3,977,424.00
210302	Түлш, халаалт	39,477,650.00	48,142,382.00
210303	Цэвэр, бохир ус	3,506,590.00	3,613,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,789,657.00	15,141,466.60
210401	Бичиг хэрэг	1,950,100.00	818,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,195,205.00	1,532,900.00
210404	Ном, хэвлэл	116,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,007,600.00	1,619,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,657,950.00	2,381,960.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал ақталсны зардал	2,362,102.00	3,288,856.60
2105	Нормативт зардал	22,825,210.00	12,229,660.00

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,683,900.00	2,812,880.00
210502	Хоол, хүнс	21,141,310.00	8,546,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	870,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,913,800.00	00.00
210604	Урсгал засвар	5,913,800.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	678,000.00	908,000.00
210702	Дотоод албан томилолт	678,000.00	908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,288,300.00	648,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	688,300.00	348,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,565,146.13	60,985,488.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	228,200.00	224,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,474,350.00	3,157,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,862,596.13	57,603,488.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,057,781.00	8,288,013.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	914,244.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	914,244.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,637,781.00	7,373,769.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,637,781.00	7,373,769.00
213504	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,237,634,165.87	36,719,653.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	20,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	20,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-20,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,237,634,165.87	36,699,653.03

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,211,492.70	217,165,217.90	60,353,576.00	413,730,286.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,211,492.70	217,165,217.90	60,353,576.00	413,730,286.60
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,242,235,108.71	1,242,235,108.71
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,211,492.70	217,165,217.09	1,297,987,742.68	1,651,364,452.47
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх	136,211,492.70	217,165,217.09	1,297,987,742.68	1,651,364,452.47

	үлдэгдэл				
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	312,640.84	312,640.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,211,492.70	217,165,217.09	1,298,300,383.52	1,651,677,093.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-312,640.84	00.00	-312,640.84
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	36,699,653.03	36,699,653.03
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,211,492.70	216,852,576.25	1,335,000,036.55	1,688,064,105.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	473,651,700.00	429,566,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	473,651,700.00	429,566,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	411,324,100.00	368,693,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,061,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,061,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,327,600.00	59,811,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,327,600.00	59,811,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	453,886,700.00	395,616,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,886,700.00	395,616,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410,828,919.00	387,328,587.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,542,471.00	257,030,860.00
210101	Үндсэн цалин	215,245,171.00	170,396,918.00
210102	Нэмэгдэл	21,118,600.00	67,921,223.00
210104	Урамшуулал	21,178,700.00	18,712,719.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,130,356.00	35,548,871.00
210201	Тэтгэврийн даатгал	22,853,618.00	25,027,586.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,486,129.00	2,636,683.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,090,193.00	2,107,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,222.00	544,677.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,182,194.00	5,232,225.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,596,187.00	55,612,056.00
210301	Гэрэл, цахилгаан	2,734,397.00	3,977,424.00
210302	Түлш, халаалт	39,355,200.00	48,021,632.00
210303	Цэвэр, бохир ус	3,506,590.00	3,613,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,182,705.00	18,578,600.00
210401	Бичиг хэрэг	1,541,300.00	961,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,195,205.00	1,532,900.00

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	142,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,710,000.00	2,061,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,093,500.00	8,522,800.00
2105	Нормативт зардал	39,959,300.00	9,612,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,527,100.00	1,550,000.00
210502	Хоол, хүнс	25,841,300.00	7,191,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,590,900.00	870,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,868,800.00	3,284,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,955,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,913,800.00	3,284,700.00
2107	Томилолт, зочны зардал	678,000.00	908,000.00
210702	Дотоод албан томилолт	678,000.00	908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,288,300.00	648,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	688,300.00	348,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,582,800.00	6,105,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	228,200.00	224,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,354,600.00	5,881,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,057,781.00	8,288,013.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	914,244.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	914,244.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,637,781.00	7,373,769.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,637,781.00	7,373,769.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,765,000.00	33,949,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,765,000.00	33,949,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,765,000.00	33,949,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,765,000.00	33,949,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,765,000.00	33,949,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,765,000.00	-33,949,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,504,700.00	420,216,687.00	8,288,013.00	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,504,700.00	420,216,687.00	8,288,013.00	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,504,700.00	420,216,687.00	8,288,013.00	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,463,500.00	257,030,860.00	6,432,640.00	97.6
210101	Үндсэн цалин	169,552,000.00	170,396,918.00	-844,918.00	100.5
210102	Нэмэгдэл	71,912,200.00	67,921,223.00	3,990,977.00	94.5
210104	Урамшуулал	21,999,300.00	18,712,719.00	3,286,581.00	85.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,567,600.00	35,548,871.00	18,729.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	25,029,100.00	25,027,586.00	1,514.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,634,600.00	2,636,683.00	-2,083.00	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,107,700.00	2,107,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	526,900.00	544,677.00	-17,777.00	103.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,269,300.00	5,232,225.00	37,075.00	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,526,300.00	55,612,056.00	914,244.00	98.4
210301	Гэрэл, цахилгаан	3,988,000.00	3,977,424.00	10,576.00	99.7
210302	Түлш, халаалт	48,538,300.00	48,021,632.00	516,668.00	98.9
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	3,613,000.00	387,000.00	90.3
2104	Хангамж, бараа материалын зардал	23,232,600.00	22,786,800.00	445,800.00	98.1
210401	Бичиг хэрэг	961,100.00	961,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,761,100.00	1,532,900.00	228,200.00	87.0
210404	Ном, хэвлэл	217,600.00	00.00	217,600.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,792,800.00	13,792,800.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	9,649,300.00	9,612,100.00	37,200.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,587,000.00	1,550,000.00	37,000.00	97.7
210502	Хоол, хүнс	7,191,800.00	7,191,600.00	200.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	870,500.00	870,500.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,864,700.00	22,864,700.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	1,580,000.00	1,580,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,284,700.00	3,284,700.00	0.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	917,700.00	908,000.00	9,700.00	98.9
210702	Дотоод албан томиллолт	917,700.00	908,000.00	9,700.00	98.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	648,200.00	648,200.00	0.00	100.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	348,200.00	348,200.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15634800.00	15205100.00	429,700.00	97.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	652,900.00	224,200.00	428,700.00	34.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,981,900.00	14,980,900.00	1,000.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,504,700.00	420,216,687.00	8,288,013.00	98.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	368,693,700.00	361,319,931.00	7,373,769.00	98.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	368,693,700.00	361,319,931.00	7,373,769.00	98.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,811,000.00	58,896,756.00	914,244.00	98.5
132001	Орон нутгийн төсвөөс	59,811,000.00	58,896,756.00	914,244.00	98.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,061,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,061,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,061,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,061,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,061,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,061,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,061,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэл, хүүхдийн хоолны нормативт зардал, шилэн данстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчмэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 472.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.4 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	00	0,2	0.2
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	98.6	110.0	11.4
Үндсэн хөрөнгө	1,552.7	1,578.5	25.8
Нийт хөрөнгө	1,651.3	1,688.7	37.4
Өр төлбөр	00	0.6	0.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,651.3	1,688.1	36.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,651.3	1,688.7	37.4

Бараа материалын дансны үлдэгдэл 110 сая төгрөг болж 11.4 сая төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна. Үүнд:

-Боловсролын яамнаас 2.3 сая төгрөгийн хүүхдийн тоглоом наадгай, зөөлөн эдлэл үнэ төлбөргүй нийүүлэгдсэн.

- Тооллогын комиссын үр дүнгээр илэрсэн 2.3 сая төгрөгийн бараа материалыг ангилан орлого авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,578.7 сая төгрөг болж 25.8 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байгаа нь дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Батлагдсан төсвөөс 14.3 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн болох тавилга тоног төхөөрөмж, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчид хүсэлт гаргаж, шийдвэрлүүлсэнээр 19.6 сая төгрөгийн компьютер, принтер, болон бусад сургалтын хэрэглэгдэхүүнд зориулж тоног төхөөрөмж авсан байна.
- Боловсролын яамнаас 16.8 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн байна.
- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгө актлах тухай шийдвэрээр ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй 13 нэр төрлийн 18.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 31.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 78 нэр төрөл бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн 31.4 сая төгрөгөөр өртгийг шинэчлэн тогтоосон байна.
- Тайлант хугацаанд 57.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг тус тус нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 01 дугаар тогтоолоор улсын төсвөөс 411.9 сая төгрөг, орон нутгын орлогоос 59.8 сая төгрөгөөр, зарлагын төсвийг нийт 471.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 1 дугаар тогтоолоор 1 удаа тодотгол хийж, тус байгууллагын төсвийг 42.2 сая төгрөгөөр бууруулж төсвийн зарлага 429.5 сая төгрөг болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 471.7 сая төгрөгийн төсөв баталснаас 411.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 58.9 сая төгрөг, санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 368.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 59.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 420.2 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 8.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420.2 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас 195 хоног хичээллэхээс 101 хоног хичээллэсэнээр, нормативт зардал, байр ашиглалт, үндсэн цалинтай холбоотой тогтмол зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар нийт 1.1 сая төгрөгийн орлогыг хүлээн авсан. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 тоот тушаалаар, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтаар 0.3 сая төгрөгийн орлого авсан.
- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/118 тоот захирамжаар ариутгал халдваргүйжүүлэлт болон хог хаягдал зайлуулах зардалд 0.8 сая төгрөгийн орлого авсан.

Нэмэлт төсвийн дансанд хүлээн авсан орлогын зарцуулалтын эрхийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журамд заасан баримтын бүрдлийг ханган НТ№1 маягтаар төрийн санд хүргүүлж эрх нээлгэж зориулалтын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх, хог хаягдлыг усгах, зайлуулах ажилд зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад батлагдсан төсөвт зардлын дүнд 19.9 хувийн хэмнэлт гаргасныг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот шийдвэрээр зохицуулалт хийж бууруулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэээллийг шалгахад 772.5 сая төгрөгийн 72 мэдээллийг ил тод байршуулахаас, 455.6 сая төгрөгийн 56 мэдээллийг байршуулж, 316.9 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн. Зөвлөмжийн биелэлт хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 355.6 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 3.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 340.1 сая төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч, 11.9 сая төгрөгийн 1 акт тотоолоо.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 3.6 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийн дүнг, нягтлан бодох бүртгэлийн цалингийн зардал, НДШ-ийн зардалтай тулган шалгахад үндсэн цалингийн зардал 2.5 сая төгрөгийн зөрүүтэй, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 0.6 сая төгрөгөөр бууруулах бичилт хийж нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг бууруулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх зарчим, 14.4.6.бүх зардал гэсэн заалтуудад нийцэхгүй нийцэхгүй байгаа тул аудитын хугацаанд залруулсан.
2. Гэрэл цахилгааны 0.5 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бичилт хийсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.10.Бараа ажил үйлчилгээний зардлыг бүртгэх гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул аудитын хугацаанд залруулсан.

4.2 Төлбөрийн акт

4.1 Хүнсний материал дансны жилийн эцсийн үлдэгдэл нь 27.8 сая төгрөг бөгөөд үүнээс 11.9 сая төгрөгийн 7 нэр төрлийн бараа материал нь түргэн муудах чанартай бүтээгдэхүүн байна. Эдгээр 7 нэр төрлийн 11.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг түүвэрчлэн цахим болон биет хэлбэрээр тооллого хийхэд байгууллагын агуулахад биетээр байхгүй хүнсний материал дутагдсан зөрчил илэрсэн нь “Төсвийн тухай хууль” 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;” 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” гэсэн заалтуудад нийцэхгүй “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт е-баримтаар дэмжигдсэн эсэх

1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 22.3 сая төгрөгийн гүйлгээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4. доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4. доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Нормативт зардал

2.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны зардлыг тулган баталгаажуулалт хийж шалгахад, нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг 0.9 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан нь хоолны зардлын норматив тогтоох тухай Засгийн газрын 2019 оны №450 дугаар тогтоолын 1 дэхь заалтад нийцэхгүй байгаа нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны №450 дугаар тогтоолын 1 дэхь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Шилэн дансны мэдээлэл

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийг шалгахад 772.5 сая төгрөгийн 72 мэдээллийг ил тод байршуулахаас, 455.6 сая төгрөгийн 56 мэдээллийг байршуулж, 316.9 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.” заалтад нийцэхгүй байгаа нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэг	6	355.6	2	3.6	1	11.9	-	-	3	340.1

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо: 0/25

АУДИТОР

Б.ДАВААНЫМ Огноо: 0/25

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

